

**“ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ  
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч цар тахлын цаашдын төлөв байдал болон олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй эдийн засаг, худалдааны хоригуудын үргэлжлэх хугацаа, олон улсын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл тодорхой бус, нөхцөл байдал түргэн хугацаанд эрс өөрчлөгдөж байгаа энэ үед ард иргэдийн амьдралд нөлөө үзүүлдэг газрын тосны бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийн хомсдол үүсэх, тогтвортой байлгах, үнэ өсөхөөс сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах онцгой журмаар зохицуулалт хийх эрхийг Засгийн газарт олгох нь зүйтэй гэж үзэж Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа 2023 оны төсвийн орлогод хэрхэн тооцсон талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир АИ-92 бензиний нөөц хэдий хэмжээтэй байгаа болон цаашид үнийн өсөлтийг хэдий хугацаанд тогтвортой байлгах боломжтой талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж тогтоолын төслийн 3 дахь заалтад хуурамч шатахуунд хольдог нафта, керосин хамаарч байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа хэдий ч зөвхөн АИ-92 бензинээс гадна дизель түлшний гаалийн татвар тогтоох эрхийг Засгийн газарт нэмж өгөх, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж хэлэлцэж байгаа тогтоолоор хуурамч шатахуунд гаалийн албан татварыг бүрэн ногдуулахаар төслийг боловсруулсан хэдий ч Улсын Их Хурлын гишүүн онцгой албан татвараас чөлөөлөх хуулийн төсөл өргөн мэдүүлсэн нь хардлага төрүүлж байгаа тул тогтоолын төслийн 3 дахь заалтыг хасах, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа Засгийн газраас өргөн мэдүүлсэн төслүүдийг нэн яаралтай журмаар хэлэлцүүлэхээр оруулж ирж байгаад дүгнэлт хийх, цаашид эргэлзээтэй, шаардлагагүй асуудлуудыг нухацтай хэлэлцэж байх нь зүйтэй, мөн төслийн 3 дахь заалтыг дэмжих боломжгүй гэсэн саналуудыг тус тус хэлсэн болно.


“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 58.3 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Г.ТЭМҮҮЛЭН